

ТҮҮХ

**«5 ДУГААР САРЫН 4-НИЙ  
ХӨДӨЛГӨӨНД» АЖИЛЧИН  
АНГИ ОРОЛЦСОН НЬ**

Ч. БАТЦЭЦЭГ

Аугаа их Октябрийн социалист хувьсгалын нөлөөгөөр Дорнодахины улс түмэн, түүний дотор империализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний тэмцэл хүчтэй өрнөж, нийт Дорнодахины хөдөлмөрчдийн хувьсгалт сэтгэлгээнд шинэ үе эхэлсэн юм. Энэ үед Хятадад үндэсний аж үйлдвэр харьцангуй түргэн хөгжиж, түүний хэрээр ажилчин анги, хөрөнгөтөн хоёрын хоорондох тэмцэл хурцдаж байв.

Үүний зэрэгцээ хагас колонийн хоцрогдсон Хятад оронд гадаадын империалист хүчнүүд, юуны өмнө Япон улс ноёрхлоо тогтоох гэж өрсөлдөж байлаа. Японы империалистууд 1914 онд Юань Шикайн засгийн газарт «21 зүйлийн шаардлага» тулган хүлээлгээд Германы эзэмшилд байсан Шаньдун мужид хяналтаа тогтоожээ. Түүнчлэн 1919 оны 4-р сарын эцсээр Парисын бага хурлаас Шаньдун дахь Германы бүх эрх мэдлийг Японд шилжүүлэх шийдвэр гаргасан нь Хятадын ард түмний дургүйцлийг хүргэж, империализмын эсрэг хөдөлгөөн гаргах шууд шалтаг болсон байна.

1919 оны 5-р сарын 4-нд Бээжингийн Тяньаньмэний талбайд 13 дээд, дунд сургуулийн 5 мянга гаруй оюутан сурагчид оролцсон жагсаал цуглаан болов. «Үндэсний бүрэн эрхээ хамгаалъя», «Шаньдунд эрхээ сэргээе», «21 зүйлийн шаардлагыг хүчингүй болгоё», «Үндэстний урвагчдыг цээрлүүлэе» гэсэн уриан дор оюутан залуучууд жагсаж, Японтой байгуулсан эрх тэгш бус гэрээнд гарын үсэг зурсан Бээжингийн засгийн газрын сайд Цао Жүлиний байрыг шатааж, Японд сууж байсан Хятадын элчин сайд Чжан Цзунсяний биед халджээ. Хятадын эрх баригчид цэрэг цагдаагийн хүчээр жагсагчдыг хөөн тарааж, 32 оюутныг баривчилсан байна.<sup>2</sup> Гэвч хөдөлгөөн намдсангүй, харин ч бусад олон хотод өрнөж, хүн амын янз бүрийн давхаргыг хамарчээ.

Ялангуяа Шанхай болон үйлдвэрийн бусад хотуудад ажилчдын хөдөлгөөн, ажил хаялт гарсан нь асар их ач холбогдолтой болжээ. Ажилчид ажлаа хаяж, Циндаог эзлэн авах гэсэн япончуудын түрэмгий санаархлын эсрэг, Хятадын тусгаар тогтнолыг хамгаалахын төлөө тэмцэж байлаа. Ажилчин ангийн энэ хөдөлгөөн бол Хятадын түүхэнд гарсан анхны томоохон хөдөлгөөний нэг байсан бөгөөд эндээс ажилчин анги цогцлон бүрэлдэх эх үүсвэр тавигдсан юм. Харин энэ үед Хятадын ажилчин анги биеэ даасан нийгэм— улс төрийн хүчин хараахан болж чадаагүй байв.

1919 оны 5-р сард Шанхай дахь Японы эзэмшлийн үйлдвэрүүдийн ажилчид ажил хаяж, хүн тэргүүд (рикша) япончуудад үйлчлэхээ больж, усан боомтын ажилчид Японы усан онгоцуудын ачааг ачих, буулгахаас татгалзжээ. 6-р сарын эхээр эх оронч уриан дор жагссан оюутан залуучуудын хамтаар үйлдвэрийн ажилчид ажил хаях хөдөлгөөн өрнүүлжээ. Парисын бага хурлын шийдвэрийг эсэргүүцэхийн зэрэгцээ, Бээжингийн эрх баригчид оюутнуудыг цээрлүүлж байгаад дургүйцлээ илэрхийлэн

1. Ху Хуа «Чжунго гэмин ши чжан-и» («Хятадын хувьсгалын түүхийн лекц») Бээжин, 1981 он. 32-р тал.

2. История Китая с древнейших времен до наших дней. М. 1974 с. 258

6-р сарын 5-ны өдөр Шанхайн худалдаачид дэлгүүр мухлагаа хаажээ. Мөн өдөр Шанхайн хэвлэх үйлдвэр, Шанхай-Нанкин-Ханьжоу-Ниньбогийн төмөр зам бас бусад үйлдвэрийн газруудын ажилчид ажил хаяжээ. Дараа өдөр нь Шанхайн Японы эзэмшлийн үйлдвэрийн 20 мянган ажилчин ажлаа зогсоожээ.<sup>3</sup>

6-р сарын 5-аас 11-ний өдрүүдэд гарсан ажил хаялтад нэхмэл, машин механизм, хэвлэл, төмөр зам, трамвай, автомашин, телефон утас, усан онгоц, усан боомт, тамхи, төмрийн үйлдвэрүүд зэрэг 50 гаруй үйлдвэрийн газрын 60-70 мянган ажилчид оролцжээ.<sup>4</sup> Ажил хаях хөдөлгөөнд Зөвхөн Японы эзэмшлийн үйлдвэрийн ажилчдаас гадна бас Англи, Америк, Франц болон бусад гадаадын эзэмшлийн, түүнчилэн хятадын үндэсний үйлдвэрүүдийн ажилчид оролцсон байна. Ажилчдын хөдөлгөөн нь 20 гаруй муж, район, 100 гаруй хот сууринг хамарч, 1919 онд нийтдээ 90 мянга гаруй хүн ажил хаялтад оролцсон байна.<sup>5</sup>

Ийнхүү хоёр сар шахам хугацаанд үргэлжилсэн оюутан, ажилчид, худалдаачид зэрэг янз бүрийн давхаргынхан оролцсон улс төрийн анхны томоохон энэхүү хөдөлгөөн нь бүх орныг хамарч, империализм ба феодализмыг эсэргүүцсэн тэмцэл болж өрнөлөө. Хөдөлгөөнд оролцогчид үндэсний зарим урвагчдыг засгийн газрын бүрэлдэхүүнээс зайлуулж, империалист гүрнүүдтэй Хятадын ард түмний эрх ашигт харшилсан гэрээнд Бээжингийн засгийн газрыг гарын үсэг зурахаас татгалзахад хүргэлээ.

Империализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлт, ялангуяа ажилчин ангийн ажил хаялт нь улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх салбарыг хамарч, харгис хүчний ноёрхолын эсрэг чиглэсэн байлаа.<sup>6</sup> Хятадын ажилчид үйлдвэрийн гол гол төвүүдэд ажил хаяж, улс төр-эдийн засгийн тэмцлийг хослон явуулснаар эх орныхоо эрх ашгаас урвагчдад хүчтэй цохилт өгч чадсан хийгээд чухам энэ нь 5-р сарын 4-ний эх оронч хөдөлгөөн тодорхой амжилтанд хүрэх нөхцлийг бүрэлдүүлсэн юм.<sup>7</sup>

Гэвч ажилчин анги нийгмийн манлай хүчин болоогүй, тэдний тэмцлийг зохион байгуулж удирдах нам байгуулагдаагүй, өөрийн гэсэн тэмцлийн хөтөлбөр байгаагүй билээ. «5-р сарын 4-ний хөдөлгөөн» нь хөрөнгөтний ардчилсан хөдөлгөөний шинж чанартай, империализм, феодализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний эх оронч шинэ ардчилсан хувьсгалт хөдөлгөөний эхлэл боллоо.

Ангийн тэмцлийн байр сууринаас авч үзвэл Хятадын ажилчин анги ийнхүү анх түрүү улс төрийн тавцанд идэвхитэй хүчин болон тодорч империализм, феодализмыг эсэргүүцсэн тэмцэлд хошуучилах үүрэгтэйгээр оролцсонд «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-ний ач холбогдол оршино.

3. Мөн тэнд с. 259

4. Хятадын хувьсгалын түүхийн лекц. 1981 он, 34-р тал.

5. ДДСА. 1979 No 2. 32-р тал.

6. Хятадын хувьсгалын түүхийн лекц. Бээжин, 1981 он, 34-р тал.

7. Хятадын хувьсгалын түүхийн лекц. Бээжин, 1981 он, 35-р тал.